

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ

эрдэм шинжилгээний бичиг

Том. XXXV (367)

2012

(16-28)

ҮГИЙН УТГА УЧИР *

Б.Ринчен

Нэг. Үгийн утгын асуудал

Бид цөм, монгол үгээр хэлэлцдэг. Тэгэхдээ: бид хэлээ мэддэг гэж хэлэлцдэг, боддог шүү дээ. Гэтэл, бид, өөрийнхөө хэлний чухам хичнээн үг мэддэг бол? гэж өөртөө асуулт тавьж болно. Энэ асуулт бол дэмий шалиг асуулт биш. Бид, өөрийнхөө хэлийг аль хир мэддэг вэ. Манай мэдлэг сонирхлын хүрээ аль хир өргөн байна. Бидний уншсан мэдсэний дэлгэр хомс нь аль хир байна гэдгийг магадалж мэдэхэд хэрэгтэй сонин асуулт гэж үзэлтэй.

Дэлхий дахинд хэдэн мянган жилийн бичиг үсэгтэй улс буй. Одоо сая бичиг үсэгтэй болж байгаа улс буй. Одоо хүртэл бичиг үсэгтэй болж чадаагүй, соёлоор буурай хоцрогдсон улс буй. Дэлхийн түмэн улсын дунд, манай хэл бол бичигтэй болсоор лав мянгаад жил болсон түүхтэй. Үүнд, Зөвлөлтийн монголч эрдэмтэн, академич Владимирцов нарын шинжлэлд монгол утга зохиолын хэлний тухай шинжлэн судалсан зүйл, Зөвлөлтийн Шинжлэх Ухааны Академид бэлтгэн байгаа "Монгол хэлний толь бичиг", Оросын олон эрдэмтний зохиосон "Монгол-Орос толь бичиг"-ийн зэрэг зүйлээс монголын утга зохиолын хэлний баялгийг мэдэж болохын дээр, монгол хуучин толь бичгийн зүйл, монгол дорнод хоёр хэлний толь бичгийн зэрэг зүйлд гардаг үгийн зүйлийг бүдүүвчилбэл нэг буман үг бардаагаар буй гэж болно. Бум гэж арван түм буюу өөрөөр өгүүлбэл, зуун мянган үг аж. Үүнд монгол толь бичгийн зүйлээс одоо гарын доор хялбар олдохоос хүрээлэнгийн тэр жил хэвлэн гаргасан хорин долоон мянга орчим үгтэй толь бичгийг авч, түүнээр туршилга болгож, хичнээн үг мэддэгээ нягталж болно. Үүнд цагаан толгойн дэс дараагаар жагсаасан тэр толь бичгийн үгийн эхнээс нь үзэнгүүт, утгыг бүрэн гүйцэд тов тодорхой мэддэг үгээ нэг бүртгэж, утга нь мэдэгдэх боловч сэтгэлд арай тийм гэж гүйцэд тодорхой орж өгөхгүй битүүлэг шиг бүдүүн тойм утга нь мэдэгдэх үгийг нэг бүртгэж, чухам юу ч гэсэн нь огт үл мэдэгдэх үгийг нэг бүртгэж, тэр толийн нэгэн хуудсыг үзэхдээ үгийг гурван анги ялган салгаж үзвэл нэг хуудсанд сайн мэдэхгүй нэг нэг хэсэг үг, бүдүүн тойм цээжинд орох нэг хэсэг үг, бүр мэдэхгүй нэг хэсэг үг, ийм гурван зүйлийн үг гарч ирэх буй. Энэ ёсоор тус толь бичгийн энд тэнд нь шүүж, хорь гучин газар туршин бүртгэж үзвэл хорин долоон мянган үгт толийн дотроос дундыг бодож гаргахад утга тодорхой мэдэх үг төдийчинээ, тойм төдий мэдэх үг төдийчинээ, огт үл мэдэх үг төдийчинээ гэдэг тоо гарч ирэх буй.

* Өвөр Монголын Ардын хэвлэлийн хорооноос 1953 онд монгол бичигээр 49 тал бүхий товхимол болгон нийтлэжээ.

Энэ гурван тооноос туршигч хүн, өөрийн биеийг гүйцэд мэддэг буюу идэвхтэйгээр хэрэглэх үгийн баялаг хичнээнтэй, тойм төдий мэдэх буюу огт үл мэдэхийн учир, идэвхтэй хэрэглэж чадахгүй үг хичнээнтэй байгаагаа мэдэж болно.

Тэгэхэд, энэ толь бичиг, манай бичиг утга зохиолын хэл, аман хэл, монгол хэлний олон салбар аялгууны үгийн баялгийг бүгдийг хэрхэвч багтааж чадаагүй, зөвхөн хорин долоон мянган үгтэй толь мөний тул мэдэх үгээ мэдэхгүй үгний тоотой харьцуулж бодвол, манай хэл үгээр аль хир баялаг нь гарч ирнэ.

Үгийн баялгийг эргэцүүлэн бодоход, бас үг тус бүр ер, ганц утгатай байдаггүй, зүйл зүйлийн санаа нэвтрүүлсэн олон утгатай, өргөн агуулгатай байдал гарч ирнэ. Жишээлбэл: сав гэдэг үг юм хийх амсар савтай юмны нэр байж болно. Бас орон сууцыг ч хэлсэн, орон сав гэсэн утга байж болно. Юм сурах савгүй амьтан гэх мэтэст "сав" гэж сурах авъяас хир гэсэн утгатай байж болно. Нутгийн сав гэвэл, аяга саваас бас өөр утга гарч ирнэ. Засах гэж эмтэрснийг бүтэн болгохыг хэлж болно. Малыг агтлахыг бас хэлж болно. Буруу ташааг зөв болгох, залруулахыг хэлж болно. Өвчин эмнэлгийг засах гэвэл, анагаах гэсэн утгатай болно. Ширээ засах гэвэл, энэ хоёр үг, мужаан (модоч)-ы газар очиж яривал эвдэрхий ширээг бүтэн сайн болгох байж болох боловч, хоолны газар очвол ширээнд хамаагүй, хоол хийж зочлох зочлуулахыг хэлсэн утгатай болох жишээтэй. Энэ мэт жишээгээр үзэхэд аливаа нэгэн хэлний үг цөм олон утгатай байдаг нь хэл хэлэнд байгаа үзэгдэл даруй мөн.

Тэгэхдээ, үгийн өдий төдий олон салаа утгаас ямар утгаар ухамсарлавал зохихыг хүн яаж мэддэг юм бэ? Ямар утгаар хэрэглэснийг юугаар нь танидаг юм бэ гэвэл, хүн, үг хэлэхдээ хэдэн үг холбож, үг өгүүлбэр болгодог, ба хэлсэн үг нь бусдын урьд зааж асуусан юмны хариу байдаг дээрээс урьдах хойдох үгээр тус бүрийн утга нь хэмжээтэй тодорхой болж ирдэг байна. Жишээ нь: үхрийг дээрээ шүдтэй гэж ёстой бууддаг эр шүү дээ гэвэл, бууддаг гэдэг үгийг худал хэлдэг дэмий донгосдог гэдэг утгаар хэлсэн байдал урьдах үгийн утгаар тодорхой. Хэрэв чамайг арван сумаар нэг оноход, энэ хүн, арвуулаар нь онодог, ёстой бууддаг эр шүү дээ гэвэл, бууддаг гэдэг үгийн чухамхүү буудах утгаар хэрэглэсэн нь урьдах үгээр тодорхой болж ирнэ. Тийнхүү урьдах хойдох үг нь аливаа үгийн утгыг нарийн тодорхой болгож өгдөг учраас хүний харилцан хэлэлцэх үгэнд үгийн утга нь тод томруун болж ирдэг байна. Түүгээр ч үл барам, уран зохиол, хошин зүйр үг тэргүүтэнд үгийн нь ерийн хэрэглэдэг утгаас тэс өөр болох ч ёс байгааг саях худал хэлдгийн жишээг бууддаг гэж хэлж болдгоор буюу тэнэг хүнийг цэцэн хүн гэж хошигнож хэлдгийн жишээгээр зүйрлэж болно.

Үгийн урьдах хойдох үгээр нь тодруулан ухахаас гадна бас нийгэмлигийн талаар үгийн утга өнгө өөр болох ёс буй. Жишээ нь, хувьсгалын өмнө ноён, хутагт хувилгаан богд эзэн, харц боол, ард тайж гэдэг үгийн утга өнгө нь феодалын ухааран тайлбарладаг ёсонд одоогийн бидний ухдагаас өөр байжээ.

Ардын хувьсгалаас хойш, эдгээр үгийн утга нь нийгэмлигийн талаар их л өөр болж ирэв. Түүнээр ч үл барам, гүн ухаан, улс төрийн зэрэг нэр томъёоны зүйлд шинээр ухаарч, өөрөөр ойлгогдох болсон зүйл ч гарч, үзэл суртал харилцан өөрийн учраас нэгэн нэр томъёо, нэгэн үгийг нийгэмлигийн талаар өөр өнгө утгатай болох ёс гарч, хуучин феодал, хөрөнгөтний ухаарал тайлбарлалтаас шал өмнөөр тайлбарлан үзэх зүйл ч хувьсгалаас хойш гарч байгаа нь манай улсын хөгжлөөс үндэслэн гарч байгаа үгийн хөгжлийн зүйл мөн. Жишээг өгүүлбэл, манай хувьсгалт сэхээтэн, ардууд, эв хамтын ёс, коммунизм гэдэг үгийн утгыг хөрөнгөтний сурталтнаас өмнөөр ухаардаг, үүнд жишээлбэл, "Францын бага ларүс" гэдэг тайлбар тольд коммунизм гэдгийг

тайлбарлахдаа (зовлон жаргалан) сайн мууг адил тэгшээр хуваан эдлэж, хүн төрөлхтөний сайхан байдлыг бататган зохиох гэсэн систем гэж тайлбарлажээ. Үүнийг бид хөрөнгөтний үзэлтний тайлбар гэхээс биш, чухамхүү шинжлэх ухааны тайлбар гэж үзэхгүй юм. Тэрчлэн, бидний пролетари идеализм гэх мэт үгийг ухамсарлах нь, хөрөнгөтний улс дахь хөрөнгөтний үзэл сурталтнаас өөр бөгөөд марксизм ленинизмийн шалгарсан зохиолч нарын үндэслэснийг баримтлан үздэг байна.

Бас хөдөлмөрийг хуваарилан, төрөл төрлийн мэргэжлийг баримтлах үндсэн дээрээс ажил мэргэжлийн талаар үгний утгад өнгө ялгамж буй болдог ёс нь операци гэхэд эмч хүн, мэсийн засал хийхийг бодох, банк нягтлан бодохын ажилтан, дебит кредит мөнгөний гүйлгээ бодох, цэргийн генерал бол өдийчинээ төдийчинээ их цэргийн нэгтгэл, дивиз бригад хөдөлгөн байлдах зэргээр мэргэжсэн зүйлдээ анги анги юм ухаарах ёс буй.

Үгийн утга хэрэглэлийн энэ байдлыг үзэхэд, ерөнхий олон зүйлийн утгатай бөгөөд хойдох урьдах үгийн байдлаар тухай тухайд оносон нэг нэг утгатай болдог байна. Энэ учир, үгийн зүйл, хэлний нэгжийн хуваарь олон салаа утгатай авч, үг өгүүлбэрийн хэрэглэлд нэг утгаар хэрэглэдэг байна. Тэгэхдээ, үзэл суртал, боловсрол, ахуй байдлын хэрэгцээний холбогдол, бас уран зохиолч хүн, хэлний аргаар уншигч сонсогчийн сэтгэлд нөлөөлөх зориуд санааны байдал зэрэг олон зүйлийн шалтгаан байж болно. Тийм дээрээс нэгэн хэлтэн дотор ч нэгэн үгийг янз янзаар ухамсарлах ёс байж болохыг жишээлбэл, англи хэлэнд учрыг мэдэх тэргүүний ажилчин хүний нэг янзаар ухаардгийг хуучнаа баримталсан, хоцрогдмол үзэлтэй англи хөрөнгөтөн хүн, шал ондоогоор ухаарч болно. Тэрчлэн, манай монгол хэлэнд жишээ авч хэлэлцвэл, давхар хүйсдэх гэж нялх төл малын нэгэн зүйлийн өвчнийг малын эмч ухаарахдаа, хүйсээр өвчний микров (хумх хорхой), ариун цэвэр үгүй байдлаас халдсан өвчин гэж үздэг бол тэр учрыг үл мэдэх зарим хүн, эхээс давхар хүйстэй гардаг учраас тэгж өвчин тусдаг гэж ухаарсан байна.

Саа гэж нэг өвчин буй. Түүнийг зарим хоцрогдонгүй хүн лус савдаг мэтийн хүн бусын хорлол хөнөөл гэж ухаардаг, их эмч хүн ухаарахдаа, мэдрэлийн системийн нэгэн зүйлийн өвчин гэж ухаардаг мэт бөгөөд үгийн утга эвдрэх хувьсах, нэмэгдэх хасагдахын учир нь цөм хүний нийгэмлигийн амьдралын нөхцөлтэй холбогдолтой зүйл мөн.

Хоёр. Үгийн утгын гол нь

Нэг үгийн олон утгатай байдаг ёсны хажуугаар өөр өөр голтой үг, гагцхүү дуудлага адилтай байж болдог ёс буй. Үүнд, энэ хоёр ёсыг харилцан ялгах ёстой. Жишээлбэл, юм оёдог зүү, чи үүнийг зүү гэдгийн зүү, өндөр намын нам, улс төрийн нам, буудлагын бай (зарим газарт харвахыг бай харвах гэж хэлнэ), чи энд бай хоёрын бай, гарахын гар, гар хөлийн гар, худгийн лай (шавар), үйлийн лай гэх мэтэс цөм утга өөр, гарал өөр, тус тус үг бөгөөд гагцхүү дуудлага адил зүйл гэж үзэх ёстой. Үүнд хэлний шинжлэлийн ёсонд дуудлага адил үг, бичлэг адил үг гэж хоёр зүйл ялгадгийг монгол хэлэнд жишээлэхэд, аман аялгуунд мориноос буухын буу, бууддаг зэвсгийн буу (зарим газарт бууг пуу гэнэ), уул нурууны уул, уул нутгийн уул, харах сахирын харуул, харах хусахын харуул цөм дуудлага адил боловч, уг гарал нь өөр, өөр үгнээс үүсчээ. Иймд дуудлага адил үг, санаа харилцан огт нийлэхгүй тул, гаа гэж нэгэн зүйл ургамлын нэр, га гэж арван ар газар гэсэн нэгэн зүйл хэмжээ, хэдийгээр дуудлага ав адил боловч газрын хэмжээ *га* нь *гаа* гэдэг ургамлыг нэрлэсэн нэрийн салбар хэрхэвч биш, тус тус гаралтай, биеэ даасан үг бөгөөд гагцхүү дуудлага нь санамсаргүй нийлсэн зүйл гэж үзэгтүн. Нөгөө олон салаа

утгатай үгийн зүйл бол ам гэж бууны ам, далайн ам, уулын ам, хүний ам, торго бөсийн ам гэх мэтээр өдий төдий харилцан бараг адилшаамаар үгүй юмыг ам гэдэг боловч, нягталж бодвол, нутгийн гол санаа нь энэ олон салбарт нэг байж, түүнээс зүйрлэн салбарласан байдал гарч ирнэ. Бууны ам гэж нэг ангайсан юмыг хэлжээ. Хүний ам гэж бас нэг ангайсан юм гэсэн санаа. Уулын ам гэж бас нэг ангайсан өндөр юмны хоорондох газар, далайн ам гэж, ус газрын зүг дотогшлон ороход хоёр хажуугаар нь ангайсан газар, байгаагаар зүйрлэн нэрлэжээ. Торго бөсийн ам гэж хоёр үзүүрийг нийлүүлэн эвхэж дөрвөлжлөн хэмжихэд мөн ангайдаг байдлаар зүйрлэн нэрлэсэн нь цөм, нэгэн гол утгаас үндэслэн салбарлаж зүйрлэн жиших зэргээр хэд хэдэн салбар утга буй болж, гол утга нь тэр олон салбар утгыг цөм хэлхэн холбож, олон салаа утгат нэгэн үг болгосон нь, дуудлага адил, утга шал өмнө үгээс ялгаатай аж.

Тийнхүү салаа олон утгатай нэгэн үгийг аль утгаар нь хэрэглэснийг буюу шал өмнө утга гаралтай бөгөөд гагцхүү дуудлага нэгтэй үгийг чухам алийг хэрэглэснийг тухай тухайн үг өгүүлбэрт хойно урд нь орсон өөр үг ухагдахуунаар тодорхой болгон ялгаж өгдөг байна.

Гурав. Нэр томъёо, жирийн үг хоёрын ялгаа

Үгийн аяыг нягтлан үзэхэд, нэгэн хэсэг нь манай өдөр тутмын аж зуухад хэрэглэх үгийн зүйл бөгөөд шинжлэх ухааны аймаг салбарт тусгайлан оноосон утга ухагдахуунгүй үгийн зүйл байдаг. Тийм боловч, огт утга ухагдахуунгүй хоосон сул үг биш, манай хэлний нийтийн сан болж, хойдох урдах үгийн утгыг тодочлон үзүүлэх байдлаас уламжлан санаа нь тухай бүр өөр утгыг нэвтрүүлэх үг буй. Жишээлбэл, шаах гэдэг үг, хага шаах гэвэл эвдэх гэсэн санаатай болж, майхан шаах гэвэл босгох барих гэсэн утгатай болж, хадаас шаах гэвэл зоох, хатган оруулах гэсэн утга ухагдахууныг нэвтрүүлэх аж.

Нөгөө талаар, ийнхүү олон утгатай үгийн хажуугаар ганц юмыг чиглүүлсэн утгатай буюу өөрөөр өгүүлбэл, утга ухагдахуун нь хэмжээ хязгаартай, оноосон нэг санаа бүхүй үг байдаг байна. Тийм үгийн зүйл хошоод гурваад зэргээр ч нийлэн, ганц утга ухагдахууныг илэрхийлэн нэвтрүүлэх нь байгааг жишээлбэл, устөрөгч хүчилтөрөгч гэдэг хоёр үг бол цөм нэгжгээд хийг нэрлэхээс өөр утга ухагдахуун үгүй аж. Тэрчлэн, нэмүү өртөг, хүчил, исэл, дасгал, онол, бага хурал, их хурал, үндсэн хууль гэх мэтийн үг бол доор доороо тухайлсан нэгэн утга онолттойгоор жирийн үгнээс ялгамжтай болж, хэрэглэх хэрэгцээ хэрэглэл нь тодорхой бөгөөд тухайн санааг бусад юмтай хутгалцуулахгүй тодорхой болгож өгдөг байна. Ийм үгийн аяыг нэр томъёо гэдэг юм. Юмны үнэн учрыг танин олж, тааварлан бодож энэ билүү тэр билүү гэдгээ, чухам тэр байна гэж мэдэх зүйлд нэр томъёо их чухал үүрэгтэй учир, ёстой эрдэмтэн нүгүд, их их зохиолч нар, улс төрийн зүтгэлтэн нүгүд шинжлэх ухааны нэр томъёог нарийн томруунаар боловсруулах гэж их оролддог юм. Ленин, Сталин нарын зохиолыг үзвэл шинжлэх ухааны нарийн тодорхой нэр томъёоны хамт, бас улс төрийн нэр томъёог нарийн боловсруулахыг энэ учраас тун чухал болгожээ. Ерөнхий, хавтгай утгатай, олон тийш нь аваачин бодож болдог нэр томъёо байвал, түүнийг тогтоохдоо асар нарийвчилсангүй юм уу, тогтоогчдын чадал нь мөхөстсөний шинж хэмжээ хязгаартай учраас сэтгэлийн хөдөлгөөн, баярлах бахдах, жигших зэвүүцэхийн зэрэг сэтгэхүйн өнгө байдал, нэр томъёоны зүйлд бараг байдаггүй шахуу гэж хэлж болно. Жишээлэхэд манай ах нар! гэхэд, ах нараа бахдаж сүр бадруулан хэлж болно. Бас, өнөөх болдог үгүй хэцүү амьтад гэсэн утгаар ч хэлж болно. Гэтэл, хүчилтөрөгч хий, хими, алгебр гэдэг нэр

томъёог энэ мэтийн байдалтайгаар хэрэглэхэд бэрх байдаг нь, тухайлсан нэг утгатай, санаа агуулга нь хэмжээтэйн учир тийм байдаг байна.

Дөрөв. Үгийн бодтой хийсвэр хоёр зүйлийн утгын учир

Орос, франц, англи, монгол зэрэг боловсон үгээр хэлэлцэгч, одоо цагийн гүйцэд сургуультай, ерөнхий төгс боловсролтой сэхээтэн хүн, бодтой, биетэй юмыг нэрлэсэн, ширээ сандал, тос гэх мэт үг, нөгөө талаар цаанаа биетэй, бодтой юмгүй, гагцхүү ухаанаар мэдэгдэх ухагдахууныг өгүүлсэн сэтгэл, санаа, хүсэл, зориг гэх мэт хийсвэр ухагдахуун үгийг, энэ үг бол биетэй юмны нэр үг, тэр нь бие бодгүй хийсвэр юмны үг гэж ялгааг нэг их хэцүү юм болгоод, хооронд нь зааг тавьж, энэ бодтой, биетэй юмны үг, төстэй боловч ондоо юманд үзвэл болохгүй гэж үздэггүй нь юмыг хийсвэрлэн сэтгэхүйн чадал бүхүйг үзүүлж байгаа хэрэг. Гэтэл, зарим боловсролоор нимгэн хүн буюу хэлэнд биетэй, бодтой юмны үгийг голчлоод, утга ухагдахууныг үзүүлсэн хийсвэр үг буюу тэр гэж, нэг тийм юм гэсэн санаа гэх тийн мэдэхийн үгийн зүйл асар боловсроогүй буюу тийм үгийг хэрэглэх нь төвөгшөөлтэй үзэгддэг ёс буй. Жишээлбэл, өмнөд Америкийн зарим индиан аймгийн хэлийг судлагсадын тэмдэглэснийг үзвэл, тэр нутагт янз янзын тоть шувуу байдагт тус бүрд нь нэртэй боловч, нийтэд нь нэрлэх ерөнхий тоть гэсэн нэр байдаггүй гэж тэмдэглэсэн байна. Тэрчлэн, зарим шинжигчин, Ява арлын зарим аймгийн янз бүрийн адгуусан амьтан, шувуу хорхой шавьжийн нэр байдаг боловч, адгуусан амьтан гэдэг ерөнхий нэр, жигүүртэн шувуу гэж олон зүйлийн шувууг ерөнхийлсөн хийсвэр нэр, шоргоолж, цох мэтийг ерөнхийлсөн хорхой шавьж гэдэг хийсвэр нэрийн зүйл алга (үгүй) байна гэж тэмдэглэжээ. Энэ мэт жишээ баримтууд олон байдаг байна.

Энэ бүгдийг үзэхэд, ерөнхийдөө тийм юм байдаг гэж ухах ерөнхий тийн мэдэхийн зүйлийг нэвтрүүлэх үг дутуугийн хараа буюу ерөнхий тийн мэдэхийн дутуу дулим байгаагийн шинж. Ийм байдалтай хэлэнд ерөнхий тийн мэдэхийн санаа утга байдаггүйг аж төрөхдөө хэрэглэдэг биетэй, бодтой юм тус бүрд оноосон үг олонтой, бодтой юмны нэрийн олноор аргацаадаг байна. Жишээг хэлэхэд зарим эрдэмтэн, Лапун гэдэг умард зүгийн нэгэн аймагт зүйл бүрийн мөсний байдлыг нэрлэх хорь шахам үг байдаг гэнэ. Тэгэхдээ, ерөнхий мөс гэсэн үг байхгүй ч байж магад. Хүйтнийг нэрлэхдээ бас арван нэгэн үг байдаг.

Мөн тэрчлэн, цас мөсийг нэрлэхдээ янз бүрийн байдлыг тус бүр тодорхойлсон дөчин нэгэн нэр байдаг гэнэ. Тэгэхдээ, дөчин нэгэн зүйлээр ялгаж нэрлэдэг юм нь бүгд нийлж цас гэсэн нэгэн тийн мэдэхийн дөчин нэгэн хэлбэр үзэгдэл мөн гэгчийн санаа орж тэр тийн мэдэхийг нэрлэх үг буй болоогүй ч байж болно. Ийм байдал манайханд байж болно. Жишээлбэл, тос гэдгийг зарим боловсрол нимгэн хүн ухаарахдаа, өөхний тос, шөлний тос, шар тос, цагаан тос гэдэг хэдэн юмыг тос гэж ухаараад, энэ л хэдийг тос гэж хэлдэг юм даа гэж орос хэлний масло гэдэг үгтэй тийн мэдэхийн талаар адил утгатай гэдгийг олж мэдээгүйн учир, машин тэрэгний тосыг тос гэснийг мэддэггүйн зэрэг жишээг дурдаж болно. Тэрчлэн, зарим хийсвэрлэн бодож чадахгүй, бодтой юмнаас ухаан санааг аргамжаастай, ерөнхий боловсролгүй хүн, ширээ гэж, монгол айлд дөрвөн хөлтэй, дээрээ хавтастай нэг юм байдаг гэж монголчуудын хэрэглэдэг бодтой нэгэн юмыг ширээ гэж ухаараад, харахад нь хөл байхгүй, хөлийн оронд хоёр бяцхан авдар шүүгээ шиг юмтай, дээр нь байгаа хавтгай юм нь бас гурваад шургуулгатай, ард нь албан хаагч хүн сууж, юм бичдэг нэг юмыг үзээд, бичгийн ширээ гэж тийн мэдэх сэтгэлд нь ороогүй учир, стол гэж, түүнийг албан тасалгааны газар, албан хаагч

тушаалтны хэрэглэдэг юм гэж ухаардаг нь, мөн өнөөх бодтой юмнаас аргамжаастайн шинж. Тэрчлэн, зарим этгээд, хятад мужаан (модоч, уран) монгол дархны хийсэн шүүгээ бол шүүгээ, түүнээс өөр маягийн шүүгээ бол шүүгээ биш *ашгаа*, *шахаа*, *шкав* гэж ухаарч байдаг нь орос хэлний *шкав* гэдэг нь манай хэлэнд шүүгээ гэж байсныг хэлсэн юм. Шүүгээн зүйл, хэлбэр байдал ямар ч байж болно гэж ухаараагүйг гэрчилж байгаа юм. Тийнхүү боловсролоор хоцрогдсон аймаг угсаатан буюу хүмүүст боловсрох нөхцөл бүрдмэгц, хэлэнд нь хийсвэр утга мэдэгдэхүүн, тийн мэдэхийн зүйл нэмэгдэн баяжиж ирнэ. Энэ тухай жишээг дурдвал, Зөвлөлт Холбоот Улсад умард Азийн хоцрогдсон улсын хэл нь Октябрийн хувьсгал (арван сарын хувьсгал) -аас хойш анх удаа бичиг үсэгтэй болж, түүхэнд хөгжлийн талаар туйлын сайхан нөхцөлтэй болж ирмэгц, утга зохиол, бичгийн хэлтэй болж, маш түргэнээр боловсрон байгаан жишээг зааж болно.

Бодтой нэг юмыг заасан үг, цаашид утга уужим болж, хийсвэр утгатай болохын улмаас зүйрлэн хэрэглэж, үгийн утгыг өргөн болгох ёс гарч ирдэг байна. Түүнээс болж, нэг үгэнд олон салаа утга гардаг ёс буй. Жишээг хэлбэл, хужирлах гэж малыг хужирт оруулаад, малын хужир идэхийг нэрлэсэн нэр. Хужирласан мал, хужирт их дуртай, шунан иддэг учир, тэрхүү шунан дурлах байдлаар зүйрлэж, хужир гэдгийг шунан дурлах юм, хужирлах гэж шунан дурлаж, бахаа ханахыг зүйрлэн хэлдэг болсон нь, хужир гэдэг нэгэн зүйлийн давсны зүйлээс хийсвэрлэн хөндийрүүлж түүнд махбодын талаар холбогдолгүй, гагц дур, дурлахын байдлаар зүйрлэн холбосон үг болгон хэрэглэх болсон нь, манай хүүгийн хужир нь ном оо. Шинэ сонин ном ирвэл, ёстой хужирладаг юм нь тэр дээ гэх мэт жишээтэй. Бас нэг жишээг хэлбэл, хоолой хоол хоёр цөм нэг гаралтай бөгөөд хуучин бичиг сударт хоёулыг идээ хоол гэдэг утгаар хэрэглэх нь буй. Уг гарлыг нягталбал, хоосны хоо гэдэг үндэстэй үг бөгөөд анхандаа хөндий хоосон юм гэж хоолойгоо нэрлэдэг байжээ. Тэгээд тэр хоосон юм уруугаа хийдэг идэх юмаа хоол гэж зүйрлэн нэрлэх болж, тэгсээр хөндий юм нь хоолой гэж, -ай дагавартайгаар нь тогтож, тэр дагаваргүй *qoy+la* дагавартай хэлбэр нь тэр хөндий хоосон юм уруу гэдэг юм нь болж ирсэн нь, бичгийн хэлэнд зарим эртний зохиолд хоол хоолой хоёр, харилцан гүйцэд ялгараагүй үед анхандаа аль алиныг ч адил утгаар хэрэглэж байсны тэмдэг дурсгал үлджээ. Үүнийг зүйрлэвэл манай хэлний одоогийн шашин шажин хоёр утга салаагүй ав адил боловч, хувьсгалын үес, үсэг үзэг хоёр салж, нэг нь бичгийн зураг, нэг нь бичгийн зэвсэг болж ирсэнтэй адил. Гэвч, зарим монгол аялгуунд шашин шажин гэсэнтэй адил, үзэг үсгийг адилхан хэрэглэдэг газар бас байгаатай адил хоол хоолой гэж ялгарсныг эртний бичигт ялгадаггүй байжээ. Тэгээд ялгаа гарч ирээд, хоосон юм уруугаа чихдэгийг хоол гэж, тэр хоосон юмыг хоолой гэдгээс өнгөөр нь ялгаж, цагаан хоолой, улаан хоолой гэх зэргээр ялгаад, бас зөв хоолой гэж юм иддэг хоолойгоо, буруу хоолой гэж, хүний идэж ууж байхдаа, нөгөө, юм иддэггүй цагаан хоолойг нэрлэх болж ирээд, цаашилсаар, нарийн урт хөндий юмыг хоолой гэх болж, утга нь хийсвэрдэн олширсоор ирсэн аж.

Тэгээд, зүйрлэн хэрэглэх ялангуяа уран үг найруулгыг зохиол мэтэст хэрэглэх байдлыг ажиглавал хоолой гэж, анхны "хоосон хөндий юм" гэснээс илүү, өдий төдий олон утгатай болж ирсэн нь манай хэлний утгын баялгийг үзүүлж байгаа хэрэг. Ганц нэг жишээг энд дурдвал, хоолойгоо тэжээх гэж амьдрах, амьд явахыг хэлсэн санаа. Хоолой зангирах гэж, бас, идэх юмаа зовоод идэж чадахгүй болох, дуулах гээд дуулж чадахгүй болох зэргийг хэлжээ. Сайхан хоолойтой гэдэг бол юм залгих хоолойд

хамаагүй, сайхан дуутай, сайхан дуулдаг хүн гэсэн санаа гэх мэт өдий төдий жишээ татаж болно.

Тав. Үгийн утга өөрчилдгийн учир

Үгийн утга хувьслын өөрчлөх байдлыг ажиглан үзвэл, утга агуулга нь дэлгэр болж нэмэгдэхийн ёс үзэгддэг. Жишээлбэл, онгоц гэж усанд хөвөхөд хэрэглэдэг нэг юмыг хэлж, тэгээд, уснаас гаргаж, ус хийх сав болгосноо худгийн онгоц гэдэг болж шарын шашин дэлгэрч ирэхэд онгоцтой адил урт саванд хүж шатаах болсноо хүжийн онгоц гэж онгоцонд бас нэг утга нэмэгдээд, халуун усанд хүний биеийг угаах савыг хэрэглэх болоход халуун усны онгоц гэж бас нэг утга нэмэгдээд, агаараар нисэх юм буй болоход агаарын онгоц буюу нисэх онгоц гэж онгоц гэдэг үгэнд бас нэг утга манай орчин үед нэмэгджээ. Тариа гэдэг үгэнд урьд амуу будаа тарих үрийг тариа гэдэг байсан бол өвчин нэмэх зүйлд хүний биед тарих эмийн зүйлийг бас тариа гэх болж, тариа гэдэг үгэнд шинэ утга ухагдахуун нэмэгджээ. Төмс гэж угтаа төвийсөн юм гэсэн үг. Энэ учир, хуучин зарим сударт төвөгсөн гэж үзэгддэг. Бас, зарим монгол аялгуунд ч тэгж дууддаг ёс буй. Төмбөгөр л байдлаар нь нэгэн зүйл сарана гэдэг цэцэгт ургамлын газар доор байдаг үрийг цагаан төмс гэж нэрлэж, мөн хүн амьтны нэгэн хэлбэрээр нь төмс гэдэг бол орчин үед бас угтаа Америк тивээс Европт дэлгэрч, орчин үед манай энд ногооны газар тарьдаг нэгэн ургамлын зүйлийг мөн төмс гэж нэрлэх болжээ. Тэрчлэн урьд утас гэж оёж шидэхэд хэрэглэдэг нийтгэж томсон нарийн юмыг хэлдэг байсан бол цахилгаанаар харилцах мэдээг утас гэж, ярьдаг утас гэдэг утга ухагдахуун нэмэгдээд мөнхүү цахилгаанаар нэвтрүүлэх бичгийг ч утас гэж, баярын утас явуулав, утсаар ярив гэж хэлэлцэх болсон нь хуучин утас гэдэг үгийн утга дэлгэр болж ирсэн байна. Унаа гэж унадаг юм гэсэн үг. Чухам угтаар нь үзвэл, салтаандаа хавчиж мордоод явдаг юм гэсэн аж. Үүнээр үзвэл, морь унадаг улсад гарсан үг гэж шинжиж болно. Тэгээд одоогийн хэрэглэлд бид салтаандаа хавчаад явдаггүй, зүгээр суугаад явдаг тэрэг, машин нисэх онгоцыг ч унаа гэж хэлэх болж, унаа хүлээж байна гэх зэргээр хэлэлцдэг болсон маань, үгийн утга анхныхыг бодвол өргөн болжээ. Тэгж өргөн болсон нь нийгэмлэгийн хөгжилтэй холбогдсон нь илэрхий. Энэ мэт жишээг тоочвол маш олон бөгөөд хүн төрөлхтөний хэл бүхэнд байдаг үзэгдэл гэж мэдэгтүн.

Үгийн утга өргөжин нэмэгдэх энэ үзэгдлийн зэрэгцээгээр басхүү утга цөөрөн хасагдаж хомсдохын үзэгдэл мөн нэгэн адил байдаг ёс буй. Жишээ болгож хэдэн үгийг эш татвал, үзэг гэж урьд номын үсгийг хэлдэг байжээ. Бас ном бичиг заахад хэрэглэх урт нарийн хулсыг хэлдэг байжээ. Одоо үзэг гэхэд гагцхүү бичдэг юмыг хэлэхээс биш, номын үсгийг үзэг гэж нэрлэхээ бараг байж, үзэг гэдэг үгийн утга хомсдож ирэв. Түүнчлэнхүү, урьдын цагт орос гэдэг нэр, хар үгэнд Европ зүгийн бүх улсыг нэрлэж байсан ерөнхий нэр байсан бол одоо ардын боловсрол нэмэгдсэний улмаас орос гэж олон улс үндэстний нэг нь байдаг юм байна гэж мэдэх болсноор Герман, Итали, Венгер, Франц гэх зэргийн улсыг орос гэхийг байж, гагц орос үндэстнийг орос гэх болжээ. Энэ жишээгээр үзэхэд үгийн утга нэмэгдэх, хасагдах нь цөм тухайн улсын нийтийн хөгжилтэй холбогдолтой байдал үзэгдэж байгаа хэрэг. Тэрчлэн, урьд яам гэж ямар нэгэн албаны газар бүгдийг нэрлэдэг байсан бол, одоо манай орчин үед албан газар бүрийг яам гэхгүй, яам гэдэг үгийн утга нарийжиж ирээд ерөнхий бөөрөнхий тийн мэдэхийн нэр байснаа хир хэмжээ нь тодорхой болж ирэв.

Хэлний шинжлэлд үгийн утга хувьсан өөрчлөхийн энэ үзэгдлийг шинжлэхдээ, хүний материал аж амьдралын хөгжин боловсорсоныг дагаж, хэл нь хөгжин, үгийн утга

ухагдахууны зүйл, мөн тэр материал байдлын улиран хөгжсөнөөс болж хувьсдагийг магадлан шинжилжээ. Үүнд жишээ болговол, өнөөдрийн бидний онгоцоор ниснэ гэж утсаар ярьсныг манай ахад шинэ шугамаар нэвтрүүлэн мэдэгдээрэй гэж хэлэхийг цахилгаан утас, нисэх онгоц зэргийг үзээгүй учир тэдгээрийн тийн мэдэх ч сэтгэлд нь байдаггүй газрын монголчууд, усаар явдаг онгоцоор яаж нисэх гэж байгаа юм бэ? утас шидмэсээр ярих гэж яаж ярьдаг улс вэ? шинэ шугамаар нэвтрүүлэн мэдэгд гэж, дөрвөлжин шугамаар юм нэвтрүүлдэг, эд ер, жирийн хүн биш, шидтэн хувилгаан улс юм болов уу? үгүй бол галзуу солиотой улс юм уу? гэж гайхна байх. Жараад жилийн өмнө манай энд ч гэсэн, бидний өнөөдрийн жирийн яриа болсон энэ үгийг сонсоод, бас ингэж гайхсан байлгүй дээ. Энэ жишээгээр, манай улсын эдийн засаг, үйлдвэрлэх хүчний хөгжил, хувьсгалаас хойш манай нийгэмлэгт их өөрчлөл гарсны улмаас хэлэнд ч тэр хөгжил дусал үзэгдэж байгааг үүнээр бодон жишиж болно.

Зургаа. Үгийн сан дахь шинэ хуучин зүйлийн учир

Хэл үгийн зүйл ингэж үргэлж хөгжин, зарим үг утгын зүйл нэмэгдэн дэлгэрч зарим үгийн утга ухагдахууны зүйл нь нарийжиж, зарим зүйл тухайн нийгэмлэгт байхгүй болж ирэхийн хамтад, түүнийг нэрлэж байсан үг утга ч үгүй болж, тийнхүү зарим үгийн зүйл орхигдох гээгдэх, хуучрахын зүйл гардаг байна. Жишээлбэл, занги, залан, бэйл, бэйс, даншиг, донир, соёмбо, шүнлив, шанзудба, гүрим, зэс гэх мэтийн үг түүх сударт гарахгүй болж хуучран гээгдээд, ард түмний нийгэмлигийн ахуй байдал өөрчилсөн учир, эдгээр үгээр нэрлэж байсан зүйл үгүй болж, үг нь ч түүх бичигт хэрэглэхээс биш, өдөр тутмын хэрэглэлд сонсогдохоо байж, хуучин нийгэмлиг, хуучин ахуй байдал, хуучин үйлдвэрлэлийн үгийн нэлээд олон нь улс ард нийтийн хөгжлийн улмаас хэрэгцээгүй болж орхигдсоноор хуучирсан үг болж, гагцхүү урьдын үеийн байдлыг өгүүлсэн уран зохиол түүх шинжлэлийн зохиолд хэрэглэхээс биш, ер нийтэд гээгдэж, одоо цагийн бага сургуулийн хүүхэд, пионерууд эдгээр үгийг сонсовч, сэтгэлд нь тийм юм байжээ гэдэг тийн мэдэх орохгүй болжээ. Ингэж ямар нэгэн үйлдвэрлэлийн арга хэлбэр өөрчлөх, аливаа нэгэн нийгэмлигийн харилцаа ахуй байдал, үзэл суртал өөрчлөхөд, үгийн санд энэ өөрчлөн хувьссан байдлыг таньж, өөрчлөл гардаг нь ёс аж.

Урьд ч тэгсээр ирсэн, одоо ч манай хөгжлийн улмаас өөрчилсөөр байгаа хэрэг. Үүнд гагцхүү, хуучин үг, хуучирсан үг гэж үзэхдээ тухайн нийгэмлигийн үзэгдэлгүй болсон буюу тухайн үеийн үйлдвэрлэлийн зэвсэг, аж төрөх амьдрахад хэрэглэх юм хэрэглэгдэхгүй болоход тэдэнтэй холбогдсон үгийн зүйл хуучран үгүй болдгийг ямар нэгэн боловсролын хир хэмжээ явцуугийн учраас түүний мэдэхгүй үгийг хуучирсан гэж болохгүй. Нийгэмлигийн хөгжиж байгаагийн улмаас ямар нэгэн нийгмийн үзэгдэл, тэрчлэн ахуй байдалд хэрэглэх юм, үйлдвэрлэлийн зарим зэвсэг багаж хэрэглэгдэхээ байгаад түүнтэй холбогдсон, түүнээс уламжилсан ёс заншил, мөн тэд бүгдийг нэрлэсэн үгийн зүйл орхигдсон гэж үзэх нь зөв.

Хэлэнд үргэлж шинэтгэл гарч зарим үг хуучран орхигдохын хажуугаар шинэ үг утгын зүйл буй болох үзэгдэл үргэлж байдаг. Тийм шинэ үгийн зүйл бол ахуй байдалд улс нийтийн хөгжил, үйлдвэрлэлийн зэвсэг, техник (мэргэжил) шинжлэх ухааны хөгжлийн улмаас гарч байдаг байна. Үүнд ялангуяа хувьсгалын үед улс ардын нийгэмлигийн ахуй байдалд их өөрчлөл гардаг учир, шинэтгэлийн зүйл хэлэнд нь их гардаг. Жишээ болговол, манай монгол хэлэнд ардын хувьсгалын энэ үед өдий төдий шинэ үг буй болсон нь радио, техник, машин, лаборатори (турших гэр), амбулатори (эмнэлгийн газар), комисс (гишүүдийн хурал), концерт (үдэшлэг, дуу хөгжим буюу

наадмын хурал), танц (бүжиг), фестиваль (хөөр найр, уралдаа), феодал, пролетари гэх зэргийн гадаадын үгийн зүйлээс гадна монгол үгэнд ч шинэ утга нэмэгдэн, хошоод гурваадаар нийлэхдээ шинэ утга, шинэ тийн мэдэхүйг нэвтрүүлэх шинэ үг нэр буй болсныг жишээлбэл, хувьсгалт уралдаан, таван жилийн төлөвлөгөө, ухуулагч, хувьсгал, хамтрал, хоршоо, хяналтын тоо, зээллэг, сугалаа, улаан булан, урилга, нийгэмлиг, оюутан, сэхээтэн, их сургууль, мэргэжил, мэргэшил, сайн малчин, нийгэм журам, эв хамт ёс, эзэрхэг түрэмгий гэх мэт өдий төдий олон үг нэрийн зүйл, манай хэлэнд шинэ тийн мэдэхүйн зүйл, шинэ утгын зүйлийг илэрхийлэх болж, онгоц, тэрэг, утас, уралдаан, тэргүүн гэх зэргийн өдийчинээ төдийчинээ хуучин үг, шинэ хөгжлийн хэрэгцээний улмаас шинэ утга нэмэгдэн, манай үг утгын сан баяжсаар байна.

Үүнд, хуучин буюу хуучирсан үгийн зүйлийг шинжлэн үзэхэд манай улс ардын өнгөрсөн түүхийн шат үеийн байдал, тодорхой харагдаж байгаа бол манай шинэ үгийн зүйлд манай улс ардын соёл хөгжиж, боловсрол нэмэгдэж, манай хувьсгалт ард түмний байлдан олсон ололт нь тодорхой үзэгдэж, мэдрэл нь нэмэгдэж урьд үзээгүй, мэдээгүй, зүүд зөнд нь ороогүй юмаа мэдэж, эрдэм чадал нь нэмэгдэж байгаа бахтай сайхан байдал тов тодорхой үзэгдэж, манай хэлний үгийн зүйлд ингэж шинэ утгын зүйл нэмэгдэж байгаа нь бидний өрнөн хөгжиж байгаагийн сайхан гэрч баримт нь байгаа хэрэг. Ийм дээрээс ардын хувьсгалаар эрх чөлөөгөө олсон манай хувьсгалт ард түмний хэлэнд нийгэм журам, эв хамтын ёс гэдэг сайхан нэр буй болсон нь манай үгийн баялаг, манай ардын хөгжлийг үзүүлж байгаа баяр бахдалтай үг. Эзэрхэг түрэмгий гэж ардын хувьсгалаар нэр томъёо буй болсон нь манай ардын хувьсгал гэх мэдрэл нээгдэж, чухам дайснаа таних чадал мэдрэлтэй болсны гэрч гэж хувьсгалын үеэр монгол үгээр эдгээрхүү шинэ утгын зүйлийг нэвтрүүлэн чадсаныг манай хувьсгалт төр, манай хувьсгалт ард түмний байлдан олсон ололт, хувьсгалт их тэмцлийн үр гавъяа гэж үзэх ёстой.

Ийм учраас эдгээр шинэ үгийн зүйл ихэд дэлгэрээд манай хилийн гаднах бусад монгол аймгийн эрх чөлөөний тэмцэлд нийгэм журам, эв хамт ёс, нам гэх мэтийн хувьсгалт үеийн эдгээр үг нэрийн зүйл нэвтэрч, тэдний дунд хувьсгалт үзэл суртал дэлгэрэх явдалд их нөлөө үзүүлж байгаа нь манай тэргүүний ард түмний гавъяа даруй мөн бөгөөд түрэмгий, найрамдах, эв хамт, журам, бүгд, нийгэм, нам гэх мэтийн эдгээр үгийн зүйл монгол хэлэнд хэдийнээс байсан авч зарим ихэд хоцрогдсон монголчуудаас эдгээр үг, бидний ардын хувьсгалаар агуулсан утга бүхүй нийгэм журам, эв хамт ёс, бүгд найрамдах улс, эзэрхэг түрэмгий гэх мэтийн нэр томъёо гарч ирэхгүй нь зүйн доторхи хэрэг. Тийм дээрээс бид шинэ үг утгын зүйлийг манай тэргүүний хувьсгалт ард түмний ололт гэж бахдан үздэг бөгөөд манай хувьсгалын их ололтыг тэмдэглэсэн үндсэн хуульд эдгээр чухал үгийн зүйл орсон нь, нийгэм журамд дэвшин орохын учир, улс орноо хөрөнгөт бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж байгаа манай хөдөлмөрчин ардын тусгаар тогтносон улсын мөн чанарыг дэлхий дахинд харуулж байна.

Долоо. Үгийн сан дахь өөр бусад үгийн учир

Дэлхийн түмэн улсын хэлийг үзвэл бие биедээ нөлөөлж, нэг нэгнээсээ үг утга авалцсаар ирснээр барахгүй, зарим нэгэн хэл, хэд хэдэн хэлний хутгалцан нийлснээс буй болсон ёс ч буй. Үүнд жишээлбэл, англи хэл гэдэг бол герман, румын хэлний хутгалцан нийлснээс буй болжээ. Франц хэл бол эртний келт хэл, түдеск хэл, румыны латинтай хутгалцан холилдсоны улмаас буй болжээ.

Герман хэлэнд грек, латин, скандинов, итали, франц хэлний үг байгаагаас гадна, монголтой нийлэх гарал сурвалж нэгтэй үг маш олон буй. Румын хэлэнд латин, славян, франц, итали зэрэг үг буй. Орос хэлэнд мөн грек, латин, англи, герман, франц, түрк, иран, монгол, хятад, энэтхэг, санскрит зэрэг үг олон буй. Зарим үг нь аль хэдийнээ орос хэлэнд харь хэлнээс орсон учир, орос биш гэж мэдэгдэхээ бараг байсан үг буй. Жишээлбэл, маш их дээр цагт орос хэлэнд бусад хэлнээс орж ирсэн учир, одоо орос биш гэж мэдэгдэхээ байсан хэдэн үгийн жишээг хэлбэл, *топор* гэдэг сүх гэсэн үг, *хлеб* гэдэг талх гэсэн үг, *кот* гэж муур гэсэн үг, *лоцадь* гэж адуу гэсэн үг, *капуста* гэдэг хагавар (ногоо) буюу манайхны хятадаар байцаа (цагаан ногоо) гэдэг ногоо, *доска* гэж самбар буюу банз гэсэн үг (үүнд манай банз гэдэг бас хятад үг шүү), *бутылка* гэдэг шил гэсэн үг (манай шил гэдэг төвд үг), *изыа* гэж байшин гэр гэх мэтийн маш олон үг буйг хэлний шинжлэлт магадлан судалжээ.

Монгол хэлэнд энэтхэг санскрит хэлнээс маргад гэж эрдэнийн чулуу (үүнийг оросын зэрэг Энэтхэг, Европын хэлэнд маргад гэдэг), *Опала* гэдэг эрдэнийн чулуу (Оросын зэрэг Европын хэлэнд мөн *опал* гэдэг), *гавар* (латин, орос хэлэнд сунжирсхийж, *камбура* гэдэг), *тарвас* (орос хэлэнд *арбуз* болон сунжирчээ), *шатар*, *шарил*, *эрдэнэ*, *махбод*, *бодгаль* гэх мэт олон үг буй. Хятадаас *цай*, *цонх*, *янз*, *яндан*, *шохой*, *гаанс*, *боов*, *бууз*, *мянтууз*, *шаазан*, *туйнуу*, *сойз*, *чүдэн* гэх зэргийн их төлөв эдийн боловсролтой холбогдсон нэр, араб улсаас *алмас* гэдэг эрдэнийн чулуу, *мад* гэж шатарт хэрэглэдэг үг монголчилбол үхлээ гэсэн үг. *Чидүн* гэдэг нэг зүйл жимс, иран хэлнээс *шаг* гэж шатарт шалдаг үг бол даруй хаан гэсэн үг, (орос хэлэнд *Шах* гэж оржээ.) *байшин*, *дуран* (нүдний дуран), *нал* эрдэнэ гэдэг улаан өнгөтэй эрдэнийн чулуу (орост урьд *лал* гэж байсан, одоо *рупин* гэх болжээ). *Бэрс* гэдэг шатрын бод (орос, мөн иранаас *ферз* гэж авчээ). Абиссин хэлнээс *анааш* гэдэг нэгэн амьтны нэр, грек хэлнээс *шижир* алтны *шижир*, *дэвтэр*, *сэлмэгдэр* гэдэг нэгэн гүрвэл шиг амьтны нэр. *Титим* гэдэг тэргүүний чимэг (орос хэлэнд *диадема*) гэж оржээ. Хотон гэдэг одоо сөнөсөн, эртний нэгэн улсын хэлнээс *данга* (мөнгө данга, мөнгө санга гэж одоо хэлэлцдэгийн *данга*). Орос хэлэнд монгол түркээр дамжин *денига* *деньги* болжээ) уйгураас *хөрш*, *хувраг* *өгүүл* *царги* гэж нэгэн зүйл гутлын нэр, (оросоор *лапути* гэдэг гутал) Испаниас *тамхи*, латин, францаас *саван* гэх зэргийн өдийчинээ төдийчинээ олон хэлнээс монгол хэлэнд эрт дээр цагт ороод одоо монгол биш гэж бараг мэдэгдэхээ байсан үг өдий төдий буй нь олон улс аймагтай эртнээс соёл эдийн талаар харилцсаар ирсний гэрч бөгөөд монголын утга соёл, эдийн боловсролыг судлах хүнд ямар ямар үед ямар ямар улсаас өөртөө байдаггүй юу юуг хэрэглэж авсныг үзэхэд их сонин сайхан байгаа хэрэг. Эдгээр эш татсан үгийн зүйл бол монгол хэлэнд нэлээд дээр эрт цагт орсон үгийн зүйл бөгөөд зарим нь аравдугаар зуунаас наашгүй үед монгол хэлэнд орсон үг буй. Дээрхи жишээний хамгийн шинэ үг нь *сэлмэгдэр* гэдэг үг бөгөөд арван долдугаар зууны сүүл хавийн тулгар бичигт гардаг юм. Бусад нь түүнийг бодвол эрт дээр орсон үг.

Гэвч, хэлний шинжлэлийн арга онолыг хэрэглэн үзвэл, эдгээрээс бүр дээр балар эртний үед монгол хэлэнд орсон үгийн зүйл гарч ирдгийг хэлний палеонтологи буюу хэлний нэн эртний үгийн шинжилгээнд магадлан үзэхэд, эрт балрын цагаас эхлэн, монголчууд бусад аймаг улстай харилцсаар ирсний гэрч баримт нь манай үгийн санд байгаа нь туйлын сонирхолтой бөгөөд Ази, Европын эртний хүн аймгийн соёл, эдийн харилцааны түүхэнд чухал холбогдолтойг дурдалтай. Энд би олныг нуршихыг хэмнэж, ганц нэг үг эш татвал, манай (зөгийн) *бал*, *мэргэн* гэдэг хоёр үгийн язгуур нь орос, санскрит, герман, прүс, литва, англи зэрэг хэлэнд мөн язгуурын утга санааг агуулсаар

байгаа бөгөөд гагцхүү авиа сэлгэх сунжрахын ёсоор хэлбэр баахан өөр мэт сонсогдовч, хэлний шинжлэлийн үүднээс үзэхэд цөм зүй тогтоол бүхүй авианы хувьсал тул, учир байдал тодорхой. Монгол хэлэнд харь хэлний үгийг хэвээр хэрэглэх орчуулахад монгол бичгийн хэлэнд тогтсон журам зарчимтай юм. Энэ зарчмын тухай орчуулгын онолд өгүүлбэл зохих тул, энд нуршихгүй. Гагцхүү, харь хэлнээс авсан үг утгын зүйлд хуулбар үг гэж байдаг нь, манай хэлний нэгэн адил байгаа бөгөөд хойшид ч олон ухааны нэр томъёоны зэрэгт хэрэглэх зарчим мөний тул, ганц нэг үг дурдалтай. Хуулбар үг гэдгийг ороост франц үгээр келикэ гэдэг юм. Утга нь, хуулбар үг гэдэг монгол нэртэй яв цав нэг. Үүнд чухамдаа, хуулбар үг гэж юуг хэлдэг юм бэ гэвэл, гадаадын үгийн маягаар өөрийн хэлэнд өөрийн үгээр буй болгосон нэр үгийн зүйлийг хэлдэг юм, тэгэхдээ, харь хэлний үгийг авалгүй, түүнийг хуулсан мэт, тэр үлгэрээр нь бүтээх аж.

Монгол хэлэнд жишээлбэл, *тийн ялгал* гэдэг хэлний зүйн нэр томъёо бол яг төвд *намье* (*nam dbye*) гэдэг үгийн үлгэр загвараар бүтээсэн нэр томъёо. Нэр үгийг хувилгахад тийнхүү ялгах ялгал нь юм аа гэж зохиосон нэрийг монголоор хэвээр нь орчуулан буулгажээ. Орос хэлэнд тийн ялгалыг *надеж* гэдэг нь мөн нэгэн хуулбар үг бөгөөд латины унах ойчих гэдэг үгнээс үүссэн унал гэдэг латин үгийн байдлыг хуулан бүтээсэн үг. Латин хэлэнд унал гэж тийн ялгалыг нэрлэхдээ, үндсэн үгнээс унаж салсан гэсэн санаагаар унал гэснийг орос, тэр хэвээр нь орос үгээр унал гэснийг орос, тэр хэвээр нь орос үгээр унал гэж хуулан орчуулжээ. Булчинг латин хэлэнд *мускул* гэдэг нь, бяцхан хулгана хулганацар гэсэн үг. Үүнээ *мус* гэж хулгана, *кул* гэж бяцхан буюу дагавраар -нцар гэсэн утгатай тул, ороост тэр хэвээр нь хуулан *мышца* гэж *мыш* гэдэг хулганад -ца гэж бяцхан юм гэсэн дагавраа залган бүтээж, латин үгнээс хуулан зохиосон нэр. Уулаас орос хэлэнд *мышца* гэж үг байсангүй. Эрдэмтэн орчуулан зохиосон үг. Манай хэлэнд *улаан булан* гэж, хувьсгалын үед нэр томъёо буй болсон нь мөн энэхүү хуулбар үгийн аргаар бүтсэн нэр томъёо.

Орос хэлэнд *улаан* гэдэг нь нэгэн зүйл өнгийн нэрээс гадна, бас сайхан, үзэмжтэй, үзэсгэлэн төгөлдөр гэсэн үг бөгөөд байшин дотроо зочныг хүндэтгэж, хамгийн үзэсгэлэнтэй сайхан буландаа суулгадгийг *улаан* буюу чухамлавал сайхан булан гэж нэрлэдэг байсан нь манай монгол гэрт хоймыг эрхэм болгодогтой адил ёс байжээ. Монгол хэлэнд хуулбар үгийн аргаар *улаан булан* гэж нэр бүтээсэн нь *улаан* гэдэг үг, *булан* гэдэг үг тус тусын утгад огт холбогдолгүй шинэ ухагдахууны нэр нийлэн бүтжээ. Тэрчлэн, таван жилийн төлөвлөгөө, зөвлөлт засаг, хамтрал, уралдаан, зүүн, баруун гэж улс төрийн талаар хэтэрхий "хувьсгалч"-ийг зүүн, хуучныг баримталсхийхийг баруун гэдэг нь орос хэлнээс хуулан авсан нэр. Үүнд зүүн баруун гэдэг хоёр үг бол орос хэлэнд бас франц хэлнээс хуулан авсан үг бөгөөд уг гарлыг үзвэл, Францад конвентын үест хурлын танхимд баахан дэвшилт этгээд нь зүүн талд, баахан хуучныг баримтлагсад нь баруун талд суудаг суудалтай байснаас нэршин дэлгэрч, яв явсаар монгол хэлэнд бас зүүн баруун гэдэг хуулбар утга нь буй болжээ. Энэ мэт орчуулан хуулах ёс нь ялангуяа шинжлэх ухааны нэр томъёоны зүйлд их арвин байдаг бөгөөд санаа нь нийтийн, үг нь үндэсний байдаг байна.

Найм. Идиом гэдэг холбоо үгийн тухай

Үгийн утга санаа нь хойдох урдах үгийн байдлаас тодорхой болдгийг дээр өгүүлсэн билээ. Үүнд, зарим үг бол хойдох урдах үгтэйгээ хамт нэгэн бүрэн иж мэт болж, ганц ганцаар салангид хэрэглэхгүй байдаг ёс буй. (иж гэж хэдэн зүйлээр нийлэн бүтсэн нэгэн

бүрэн бүтэн юмыг нэрлэдэг юм. Жишээлбэл, нэг зохиолчийн бүх зохиолын зүйлийг иж гэж хэлж болно. Хэд хэдэн дэвтэр боть нийлж нэг бүрэн зохиол болдог бол иж гэдэг юм.) Ингэж хэд хэдэн үг нийлэн, нэг утга ухагдахуун бүхүй бүрэн иж болдог ёс, хэл бүхэнд байдаг учир, тусгай нэртэй байдаг юм. Хэлний шинжлэлд үүнийг идиом гэж нэрлэдэг юм Идиомын зүйлд утга санаа нь, бүтэн идиомоос гарахаас биш, идиомын доторхи үг тус бүрд байдаггүй. Тийм учраас идиомын зүйлийг үг дагуу махчлан орчуулбал утга нь нэвтэрдэггүй гээгддэг юм. Жишээг хэлбэл, хоёр хүн, олон хүнд задруулахгүй аминчлан хэлэлцэхийг "эндээ гэж хэлэхэд" гэж монголоор ярьдгийг орос бол "нүднээс нүдэн дээр" гэдэг. Англи хүн бол "нүүр нүүртээ" гэдэг. Герман бол "Дөрвөн нүдний доор" гэдэг. Үүнд монгол, орос, англи, германд энэ дөрвөн өөр идиом үгээр яг нэг санааг илэрхийлжээ. Хэрэв монголын эндээ гэж хэлдгийг тэр хэвээр нь нөгөө гурван хэлэнд хэлдэг идиомын үгийг хэвээр орчуулбал, санаа нь мөн нэгэн адил гээгдэж, утга эвдрэхгүй, "нүднээс нүдэн дээр" яаж хэлдэг юм бэ? "дөрвөн нүдэн доор" яаж хэлдэг юм бэ? гэж гайхах болно. Монголоор бид, "түүний бие, тэр хүнд их элэгтэй юм аа" гэж хэлдэг. Монгол хэлний энэ идиомыг герман хүн хэлэхдээ "түүний бие, тэр хүний доторхи тэнэгийг залгин иджээ" гэж хэлдэг. Орос хүн хэлэхдээ "түүний бие, тэр хүнд сүнсийг хүсэн эрдэггүй" гэдэг. Монголоор майхан шаадаг, оросоор майхан хага цохидог. Үүнд санаа нэг, үг өөр учир, идиом үгийн учир утгыг мэдэлгүй орчуулбал олонхид утга санаа нь бууж өгөхгүй болно. Жишээлбэл, орост нэг идиом байгааг жишээлбэл, өөртөө хамаагүй юмаар нь битгий оролд. Өөртөө хамаагүй газар битгий чирэгдэн холбогд гэсэн утгатай орос идиомыг хүний чарганд битгий суу гэж өөрчлөн орчуулбал, тэр идиомын санааг гүйцэд мэдээгүй хүн, үгийг орчуулаад утгыг хаясан байдал илэрхий гарч ирнэ. Иймд дахиж өөрчлөн орчуулж, утгыг гээх явдал ер үзэгддэггүй байна. Хэл бүхэнд ийм идиомын зүйл захаас аван, замаас үргэлж тул, орчуулах хүн, үүнд өөрийн хэлний идиомоор баялаг байх ёстой. Тэгвэл, гадаадын хэлний тэр идиом манай хэлний энэ идиом болох юм байна. Манай хэлний энэ идиом, тухайн гадаадын хэлэнд тийм идиомтой дүйх (таарах) юм байна гэж мэдэх ёстой. Хэрэв харийн идиомын санааг мэдэвч, өөрийн хэлэнд тэр санааг нэвтрүүлсэн идиомыг мэдэхгүй бол тусгүй. Иймд өөрийн үгийн санг баяжуулах явдал чухал болно.

Үгийн утга учрын тухай бичвэл, өгүүлэх зүйл, хэлний шинжлэлийн үүднээс маш үлэмж боловч, энэ удаа үүнээр төгсгөл болгоод, харийн үг хэрэглэхдээ, чухам зайлшгүй хэрэгцээ бүхүйг нь хэрэглэхээс биш, тэр харь үгийн утга санаа нь өөрийн үндсэн хэлэнд байвал харийн үгийг илүүц хэрэглэхийн учир шаардлага байдаггүй юм. Үүнд, Ленин, гадаадын үгийг хэрэгцээгүй газар илүүц хэрэглэхийг буруушааж, ялангуяа гадаадын үгийг буруугаар ойлгон, ташаа хэрэглэхийг жигшин, орос хэлийг цэвэр боловсон болгох тухай гэж тусгайлан нэг өгүүлэл бичсэнийг дурдан тэмдэглэжээ.

Ленин бол гадаадын юм бүгдийг боол мэт бишрэн дагахыг эрс буруушааж, орос хэлний баялаг сайхныг анхааруулж байсан билээ. Оросын их эрдэмтэн, дээр цагаас, Ломоносовоос эхлэн, үндсэн орос хэлээ их л хайрлан энхрийлж, түүний гоё сайхан чадлыг хэрэглэн, улам яруу сайхан болгохыг сануулан бичиж байсан билээ. Түүний дараа Белинский гэдэг нэрт эрдэмтэн, "Ямарваа нэгэн хэлэнд орсон гадаадын үгийн оронд тэр хэлний өөрийн үгийг хэрэглэвэл тэрхүү харийн үгийг хэрэглэхээ байдаг. Жишээ нь, орос хэлэнд ялалтыг *виктория* гэж байсан нь үгүй болж, бэлгийг *презент* гэж байсан нь үгүй болжээ" гэж аль хэдийнээ ажиглан тэмдэглэсэн билээ. Манай үест нөхөр Геденов, орос хэлний хөгжсөнийг заан дурдаж гадаадын *лүзун* гэдэг үгийн оронд орос, призыв гэдэг үгээ хэрэглэх болсон нь, утгыг бүрэн нэвтрүүлэх сайхан үг мөний

тул, лүзүн гэдэг харь үг хэрэглэсний хэрэг алга(үгүй) болсныг дурдсан билээ. Оросын их уран зохиолч Максим Горький, зохиолчдын анхдугаар хуралд үг найруулгын эрхмийг онцлон чухалчилж үг хэлэхдээ: Орос хэлний боловсон баялгийг улмаар хөгжүүлэн хэрэглэж, хэлнийхээ соёлыг улам өрнүүлэхийг уриалсан тэр уриаг олон нийтээр угтан тосч авсан билээ. Энэ завсар, орос хэлний соёлын учир, Зөвлөлт Холбоот Улсын шинжлэх ухааны академийн зэрэг газраас чухал өгүүлэл шинжлэлийн зүйлийг үлэмжхэн нийтэлж, шинжлэх ухааны академийн олон шинжилгээний газрын дотор тусгайлан орос хэлний институт гэдэг шинжилгээний газар ажиллан байгаа нь орос хэлний өнгөрсөн түүхийг судлахын хамтад, бас хэлээ улам баялаг боловсон болгох талаар их л ажил хийж байгаа нь нийтэд их л сайхан нөлөөтэй байгааг дурдаад яанам. Дэлхий дээр тэргүүний соёлыг өрнүүлэн хөгжүүлж байгаа оросын ард түмний олон сайхан эрдэмтэн, дэлхий дахинд нэртэй төрийн зүтгэлтэн, нийгэм олон ардаас нь үндэснийхээ хэлийг ингэж сайхнаар хөгжүүлэн, дэлхийд хосгүй утга соёлыг хөгжүүлэгч зэвсэг болгосон үлгэр жишээг манай сэхээтэн, уран зохиолчийн зэрэг, ер зохиол найруулгыг эрхлэгч хүн бүхэн бодуштай байна.